



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/02

Арвайхээр сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 5 дугаар багт Ренчинпэлжээгийн гудамж 141 тоотод байрлах “Итгэлт Өргөө” ХХК-ийн захиалга, хөрөнгө оруулалттай Централ Таун хотхоны 1 дүгээр ээлжийн үйлчилгээний төвтэй 32 айлын орон сууцны барилга байгууламжийн угсралтын ажил дууссан тул “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу өндөр төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (А.Энхцэцэг)-д даалгасугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0003

Аймгийн Засаг даргын 2023 оны
...дүгээр сарын ...-ны өдрийн
...дугаар захирамжийн
хавсралт



**ӨНДӨР ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Г.Түвшинтөр (аймгийн ерөнхий Архитектор)
Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Б.Өсөхбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)

Ө.Алтаншагай (Зураг төслийн “Скайлайн Дизайн” ХХК-ийн архитектур)

Б.Даваадагва (“Онги ус суваг” ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер)

С.Мөнхзаяа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

М.Нинжбадгар (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Ахлах мэргэжилтэн)

Г.Энхболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Стандарт, хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Д.Мөнх-Эрдэнэ (ЭБЦТС ТӨХК"-ийн ӨВ дахь салбарын Ахлах диспичер)

Ц.Оюунтунгалаг (Өвөрхангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн)

Б.Баасансүрэн (“МХС” ТӨХК-ийн ӨВ аймаг дахь салбарын Кабель шугамын инженер)

Д.Мөнхболд (“МЦХ” ТӨХК-ийн ӨВ аймаг дахь салбарын инженер)

Захиалагч: Б.Идэр (Итгэлт Өргөө ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч: Б.Сумъяацэрэн (Итгэлт Өргөө ХХК-ийн инженер)

Нарийн бичгийн дарга: С.Мөнх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын материалын үйлдвэрлэл, Лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Т.Осоржамаа (Итгэлт Өргөө ХХК-ийн менежер)